



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж,  
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.1, 6.2.5, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхөөгүй боловч цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь Мэргэжлийн хяналтын байцаагчийн 2009 оны 11-29-145/1907, 2011 оны 01-33/33 дугаар дүгнэлтээр тогтоогдсон нийт 417,739,000.00 (дөрвөн зуун арван долоон сая долоон зуун гучин есөн мянган) төгрөгийн балансын үнэ, 166,190,498.50 (нэг зуун жаран зургаан сая нэг зуун ерэн мянга дөрвөн зуун ерэн найман төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Газрыг зориулалтын бусаар, арилжааны зорилгоор ашиглахгүй байх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001977

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн  
 234 дугаар тогтоолын хавсралт



Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй  
 акталж, данснаас хасах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл үнэ /төгрөг/
1	Барилга /контор/	м.кв	719	2002	417,739,000.00	166,190,498.50	251,548,501.50
	Нийт дүн				417,739,000.00 (дөрвөн зуун арван долоон сая долоон зуун гучин есөн мянган)	166,190,498.50 (нэг зуун жаран зургаан сая нэг зуун ерэн мянга дөрвөн зуун ерэн найман төгрөг тавин мөнгө)	251,548,501.50 (хоёр зуун тавин нэгэн сая таван зуун дөчин найман мянга таван зуун нэгэн төгрөг тавин мөнгө)